

Аудитын код: САГ-2018/164/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Юнистар Аудит ХХК-ийн аудитор М. Энхжаргал
Утас: 328735 Цахим хаяг: unistar_audit@yahoo.com



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Үндсэн хөрөнгийн талаар	4
2.9.2	ХХОАТ-ын талаар	4
2.9.3	НДШ-ийн талаар	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
3	Менежментийн захидал.....	8
3.1	Үндсэн хөрөнгийн талаар	9
3.2	ХХОАТ, НДШ-ын талаар.....	10
3.3	Дотоод хяналтын талаар.....	11
3.4	Төсөвийн зарцуулалтын талаар	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ДУУРЬ БҮЖГИЙН
ЭРДМИЙН ТЕАТРЫН ЗАХИРАЛ
Ц.ТӨВШИНТӨГС ТАНАА

2018.02.23 № 06/449
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**


Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын захирал Ц.Төвшинтөгс танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар Аудит ХХК санхүүгийн тайлангийн аудит хийлээ. /САГ-2018/164/СТА-ТШЗ/

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн 2018 оны 01 дүгээр сарын 31-нээс 2018 оны 02 дүгээр сарын 23-ны хооронд хийхээр төлөвлөн “Юнистар Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 31-нд “Юнистар Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь бүх нийтэд урлагаар үйлчлэх чиг үүрэг бүхий Монгол улсын төрийн өмчит, соёл урлагийн байгууллага мөн. Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь уран бүтээлч, соёлын ажилтны мэргэжлийн өндөр ур чадварт тулгуурлан үндэсний болон сонгодог урлагийн бүтээл/ дуурь, бүжгэн жүжиг, балет, симфони хөгжмийн бүтээл/-ээр иргэдэд үйлчлэх, өөрийн сан хөмрөгт хадаглагдаж буй дэлхийн болон үндэсний сонгодог урлагын бүтээлийг хадгалан хамгаалж, баяжуулж, мэдээллийн санг бий болгон хадгалж, зохих дүрэм, журмын дагуу нийтэд түгээж, хөдөө орон нутаг, алслагдсан дүүргийн иргэдэд тогтмол үйлчилнэ гэж үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангах ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна”, 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга /захирал эрхлэгч/ тухайн байгууллагын төсвийн захирагч байна” гэж заасны дагуу Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны төсвийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны төрийн сангаас олгож байна.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 17 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “ACOLOUS4.01*” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянах явцад дотоод хяналтын талаарх бодлого, дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт байхгүй, нэгж бүтцийн талаарх мэдээлэл байхгүй түүний дотор санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул ажиллаж байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 2,800,744.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 60,050.0 мянган төгрөг, хөрөнгийн орлого 23,335.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан орлого 128,910.0 мянган төгрөг, өөрийн орлого 228,305.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 32,084.0 мянган төгрөг нийт 3,273,429.5 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс урсгал зардалд 3,049,957.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 онд Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан байна. Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу 2017 онд 4,755,433.2 мянган төгрөгийн 140 удаа мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудас болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Сангийн яамны цахим хаягаар улирал бүрийн хуулийн хугацаанд тайлан мэдээг илгээж ажилласан байна. Үүнд тендерт оролцсон нарийн мэдээллийн тухай 3 удаа, 5 саяас дээш худалдан авалтын тухай 30 удаа, Цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлого, зарлагын гүйлгээг 49 удаа, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаар 28 удаа, бусад мэдээллийг 2 удаа цахим хуудсанд байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан 17 горим, сорилыг гүйцэтгэв.

-Дотоод хяналт байхгүй

-Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинээр тогтоож, мөрдөн ажиллаагүй

-Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварыг үнэн зөв тайлагнадаггүй

-Тайлант оны худалдан авалтаар тусгах үндсэн хөрөнгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, УСНББОУС, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант хугацаанд УДБЭТ нь БСШУС-ын багцаас зарлагдсан утсан хөгжим нийлүүлэх Хөгжим 2017/01 дугаартай тендерээр ирсэн 128,910.0 мянган төгрөгийн 22 ш хөгжмийг үндсэн хөрөнгийн орлогод аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-дахь заалтыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгч залруулга хийсэн.

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтанд байгаа 1,994,240.2 мянган төгрөгийн барилга байгууламж, 48,538.9 мянган төгрөгийн гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, 24,001.0 мянган төгрөгийн холбооны тоног төхөөрөмж, 71,818.7 мянган төгрөгийн хөгжмийн зэмсэг, 34,059.9 мянган төгрөгийн тайзны тоног төхөөрөмж, 11,669.9 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 131,061.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 140,903.2 мянган төгрөгийн тайз чимэглэлийн хөрөнгө бүртгэлтэй байна.


Энэ нь УСНББОУС 17-ийн “Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт”-ийн 49-д үндсэн хөрөнгөнд 3-5 жил тутам дахин үнэлгээ хийх нь тохиромжтой гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа элэгдлээ нөхсөн хөрөнгийн цаашид ашиглагдах жилийн хугацааг тогтоох, УСНББОУС17-н дагуу бодит үнэ цэнээр үнэлэх тухай зөвлөмж өгөх.

2.9.2 ХХОАТ-ын талаар

Тус байгууллага нь ажиллагсад олгосон хоол унааны мөнгөнөөс нийгмийн даатгалын шимтгэл хасаж хувь хүний орлогын албан татварыг суутгасан байна. 159,192.0 мянган төгрөгийн хоол унааны мөнгөнөөс суутгавал зохих дүнгээс 1,577.8 мянган төгрөгийг дутуу суутгасан байна.

Энэ нь “Хувь хүний орлогын албан татварын тухай” Монгол улсын хуулийн 22.1.4-д “шууд бус орлогод ногдуулах албан татварыг үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.” гэж заасантай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн: Ажиллагсдад олгосон унаа хоолны мөнгөнөөс ХХОАТ-ыг суутгахдаа нийгмийн даатгалын шимтгэлийг хасаагүй дүнгээс суутгаж санхүүгийн програмд өөрчлөлт хийх алдааг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

2.9.3 НДШ-ийн талаар

Нийгмийн даатгалын тайлан, цалингийн хүснэгтийг тулган шалгахад 1,221.2 мянган төгрөгөөр нийгмийн даатгалын тайлан дутуу тайлагнагдсан байна.

Энэ нь "Үнэн зөв байх", "Толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг хуулийн дагуу үнэн зөв илэрхийлж алдааг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

2.9.5 Цалингийн шилжүүлгийн талаар

Тус байгууллага нь шинээр орсон болон цалингийн картгүй хүмүүс, дуудлагаар ирсэн уран бүтээлчдийн цалинг нягтлан бодогч, бэлэн мөнгөний нярав, уран бүтээлчдийнхээ картын дансруу шилжүүлж дамжуулан өгдөг байна. Нийт 54,035.8 мянган төгрөгийн цалинг дамжуулсан байна. Үүнээс эдгээр хүмүүсийн дансаар дамжуулсан мөнгөнөөс анхан шатны баримтаар тулган үзэхэд нэр бүй 3 хүний дансаар дамжсан 10,467.3 мянган төгрөгийн цалин хөлс нь баримтаар нотлогдохгүй байна. Харин энэ тооцооноос 5,000.0 мянган төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 25-нд буцаан төлж 5,467.3 мянган төгрөгийн тооцоо үлдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг хуулийн дагуу үнэн зөв илэрхийлж алдааг дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

2.9.6 Дотоод хяналтын талаар

Тус байгууллагад дотоод хяналтын талаарх бодлого, дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт байхгүй, нэгж бүтцийн талаарх мэдээлэл байхгүй түүний дотор санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул ажиллаж байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Төсвийн шууд захирагч нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах талаар удирдлагын анхааралд хандуулсан зөвлөмж өгөх.

2.9.7 Төсвийн зарцуулалтын талаар

Тус байгууллагын төсвийн зарцуулалтын талаар авч үзэхэд тайлант жил 3,093,689.2 мянган төгрөгийн орлоготой, 3,093,689.2 мянган төгрөгийн зардалтай ажиллана гэж төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,118,898.9 мянган төгрөгийн орлоготой ажиллаж 3,118,898.9 мянган төгрөгийн зардалтай ажилласан бөгөөд төсөв 25,209.7 мянган төгрөгөөр хэтэрсэн харагдаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх

2.9.7 Санхүүгийн тайлангийн талаар

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 31-нд “Юнистар Аудит” ХХК-д ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн бодолт, цагийн бүртгэлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 131,709.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 128,910.0 мянган төгрөгийг залруулж, 2,799.0 мянган төгрөгийн 4 төрлийн зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн болно.


2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын зөхөөрлөгөөс 32,734.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр

хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ, АУДИТОР
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

М. ЭНХЖАРГАЛ
Т. ЭНХТУЯА



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Үндсэн хөрөнгийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №2****Ажиглалт**

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтанд байгаа 1,994,240.2 мянган төгрөгийн барилга байгууламж, 48,538.9 мянган төгрөгийн гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, 24,001.0 мянган төгрөгийн холбооны тоног төхөөрөмж, 71,818.7 мянган төгрөгийн хөгжмийн зэмсэг, 34,059.9 мянган төгрөгийн тайзны тоног төхөөрөмж, 11,669.9 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 131,061.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 140,903.2 мянган төгрөгийн тайз чимэглэлийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь УСНББОУС 17-ийн “Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт”-ийн 49-д үндсэн хөрөнгөнд 3-5 жил тутам дахин үнэлгээ хийх нь тохиромжтой гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа элэгдлээ нөхсөн хөрөнгийн цаашид ашиглагдах жилийн хугацааг тогтоох, “0” үлдэгдэлтэй хөрөнгүүдийг болон зах зээлийн үнээс хэт доогуур өртөгтэй хөрөнгүүдийг УСНББОУС17-н дагуу бодит үнэ цэнээр үнэлэх


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 05-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Хөрөнгөнд бүртгэлээр тавих дотоод хяналт хэрэгжихгүй бөгөөд хөрөнгийг үргүй зарцуулах эрсдэлтэй. Ил, Х, Үн, Т;

Төсвийн захирагчийн хариу

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа ихэнх хөрөнгө нь ашиглах жилийн хугацаа дуусаж 0 үлдэгдэлтэй болсон. 2018 онд Төрийн өмчийн хороонд хүсэлт гаргаж дахин үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх болно..



3.2 ХХОАТ, НДШ-ЫН ТАЛААР**Тэргүүлэх ач холбогдол №2****Ажиглалт**

Тус байгууллага нь ажиллагсдад олгосон хоол унааны мөнгөнөөс нийгмийн даатгалын шимтгэл хасаж хувь хүний орлогын албан даадаадуу а нободданаи ааеи а. Ааеёёааа олгосон 159,192.0 төгрөгийн хоол унааны мөнгөнөөс суутгавал зохих дүнгээс 1,577.8 мянган төгрөгийг дутуу суутгасан байна..

Мөн нийгмийн даатгалын тайлан, цалингийн хүснэгтийг тулган шалгахад 1,221.2 мянган төгрөгөөр нийгмийн даатгалын тайлан дутуу тайлагнагдсан байна.

Тус байгууллага нь шинээр орсон болон цалингийн картгүй хүмүүс, дуудлагаар ирсэн уран бүтээлчдийн цалинг нягтлан бодогч, бэлэн мөнгөний нярав, мөн олж ирсэн уран бүтээлчдийнхээ картын дансруу шилжүүлж дамжуулан өгдөг байна. Нийт 54,035.8 мянган төгрөгийн цалинг дамжуулсан байна. Үүнээс эдгээр хүмүүсийн дансаар дамжуулсан мөнгөнөөс анхан шатны баримтаар тулган үзэхэд нэр бүхий 3 хүний дансаар дамжсан 10,467.3 мянган төгрөгийн цалин хөлс нь баримтаар нотлогдохгүй байна. Харин энэ тооцооноос 5,000.0 мянган төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 25-нд буцаан төлж 5,467.3 мянган төгрөгийн тооцоо үлдсэн байна

Энэ нь “Хувь хүний орлогын албан татварын тухай” Монгол улсын хуулийн 22.1.4-д “шууд бус орлогод ногдуулах албан даадаадуу а ободданаи î ðèî àî î ä çî àúŋñ нободданаи а”, “Үнэн зөв байх”, “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдэлүүдийг хангахгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материал, мөнгөн хөрөнгө, санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, ашиглал шамшигдал үүсэх,

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлэх, Санхүүгийн програмыг бүрэн гүйцэт хэрэглэж 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон тодруулгыг бэлтгэн гаргах, тухайн ажил гүйлгээг цаг тухай бүрт бүртгэж тайлагнаж байх,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дүгээр сарын 05-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

**Төсвийн захирагчийн хариу**

